

ДОРНОД АЙМАГ ДАХЬ УЛСЫН  
БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС



2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Чойбалсан хот  
2020 он

## **АГУУЛГА**

**НЭГ.** БИДНИЙ АМЖИЛТ, ЗОРИЛТ, ҮНЭТ ЗҮЙЛС

**ХОЁР.** ХҮНИЙ НӨӨЦ, ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

**ГУРАВ.** СОНГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**ДӨРӨВ.** ХАМТЫН АЖИЛЛАГАА, СУРГАЛТ

**ТАВ.** ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

**ЗУРГАА.** БҮРТГЭЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ, ХАРЬЦУУЛАЛТ

- Бичиг хэргийн эргэлт
- Бүртгэл хяналтын чиглэлээр
- Иргэний улсын бүртгэл
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл
- Хуулийн этгээдийн улсын бүртгэл
- Архивын чиглэлээр хийсэн ажил

**ДОЛОО.** ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТ ШИЙДВЭРЛЭЛТ

**НАЙМ.** САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР

**ЕС.** ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР

**АРАВ.** БУСАД

**АРВАН НЭГ.** ДҮГНЭЛТ

### НЭГ. БИДНИЙ АМЖИЛТ, ЗОРИЛТ, ҮНЭТ ЗҮЙЛС

Дорнод аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь тухайн жилийн “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний биелэлт, цаг үетэйгээ холбогдуулан зохион байгуулсан шинэлэг ажил, мөн хамт олны нэгдмэл зохион байгуулалт, ажил үүргээ оновчтой зөв зохион байгуулсны үр дүнд системийн хэмжээнд дараах амжилтуудыг он дараалан үзүүлсэн.

- 2016 онд “ДЭД БАЙР”
- 2017 онд “ДӨТГӨӨР БАЙР”
- 2019 онд “ТЭРГҮҮН БАЙР”



### ЗОРИЛТ, ҮНЭТ ЗҮЙЛС

Иргэн, хуулийн этгээдэд бүртгэлийн хууль тогтоомж, үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг орон зай, цаг хугацаанаас үл хамааран хүргэх зорилгоор 2019, 2020 оныг “ИРГЭНД ОЙР БҮРТГЭЛИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ” -ний жил болгон зарласан.

### БИД:




**ШИНИЙГ САНААЧЛАГЧ, БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭТЭЙ**

**ЧАНАР, ИЛ ТОД ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДЛЫГ ЭРХЭМЛЭГЧ**



**МАНЛАЙЛАГЧ ХАМТ ОЛОН.**

ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦ, ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн Б/89 тушаалаар хэлтсийн бүтэц, орон тоо батлагдаж төрийн захиргааны албан хаагч -25, төрийн үйлчилгээний ажилтан- 4, гэрээт- 2 нийт 31 албан хаагчтайгаар аймгийн 82 мянга гаруй иргэнд төрийн бүртгэлийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна.



Албан хаагчдыг нас, хүйсээр ангилвал:




Боловсролын түвшингээр нь ангилвал:




Тайлант хугацаанд Удирдлагын акедамийн “ Төрийн захиргааны ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, Дорнод Их Сургуулийн Төрийн захиргаа удирдлагын магистрот 1 албан хаагч суралцаж, мэдлэг дээшлүүлсэн.

Мэргэжлээр ангилвал:



Бүртгэлийн байгууллагад ажилласан жилээр нь ангилвал:




2020 онд шинээр 4 албан хаагч ажилд орсон. Үүнээс:



1 ЭРЭГТЭЙ

3 ЭМЭГТЭЙ

Шинээр ажилд орсон ажилтны  
5 жилийн судалгаа



Чөлөөлөгдсөн ажилтны сүүлийн  
5 жилийн судалгаа



Тэтгэвэрт 1 албан хаагч, өөрийн хүсэлтээр 12 албан хаагч ажлаас чөлөөлөгдсөн байна.

Төрийн албан хаагчийн дэлгэрэнгүй, Төрийн албанд ажилласан жилийн, зэрэг дэвийн, нас, хүйс, боловсрол, мэргэжил гэх мэт суурь 14 судалгааг шинэчлэн гаргасан.

Төрийн захиргааны 3, гэрээт албан хаагчийн 1 сул орон тооны мэдээллийг [байгууллагын www.ubh.dd.gov.mn](http://www.ubh.dd.gov.mn) цахим хаягт байршуулж мэдээлж ажиллав.

Д/д	Тушаал, шийдвэр	Төрөл	Албан хаагчдын тоо
1.	Хэлтсийн даргын 2020 оны А/23	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэн урамшуулал олгосон	28
2.	УБЕГ-ын даргын 2020 оны Б/156	зэрэг дэвийн нэмэгдэл	21
3.	УБЕГ-ын даргын 2020 оны Б/26, Хэлтсийн даргын 2020 оны А/04	Албан тушаалын цалингийн шатлал ахиулах	10

4.	Хэлтсийн даргын 2020 оны А/01, А/26	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл	5
----	-------------------------------------	---------------------------------------	---

“Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу

Давхардсан тоогоор 35 албан хаагчийн хувийн хэргийн шинэчлэл, баяжилтыг хийж, ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтны хувийн хэргийг хадгаламжийн нэгж үүсгэн, 2 ажилтны хувийн хэргийг холбогдох байгууллагад шилжүүлэв.

Даргын дэргэдэх зөвлөл

Ёс зүйн салбар хороо

Хяналт-шинжилгээ үнэлгээний баг

Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын

Авлигын эсрэг орон тооны бус зөвлөл

Сургалт хариуцсан ажлын хэсэг

Эрүүл мэнд, спортын ажлын хэсэг

“Ил тод байдлын шалгуур үзүүлэлт”-ийг хангах ажлын хэсэг

Эцэг, эхийн зөвлөл

Терроризмоос урьдчилан сэргийлэх ажлын хэсэг

Хүний эрхийг хангах ажлын хэсэг

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл

Албан хаагчдын ажил үүргийг тэнцвэржүүлэх үүднээс 12 ажлын хэсэг байгуулан ажиллаж хэвшсэн.

Монгол Улсад бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойн баярын хүрээнд төрийн одон медалиар 2, ХЗДХЯамны шагналаар 3, УБЕГ-ын шагналаар 3, аймаг орон






нутгийн шагналаар 4 албан хаагчийг тус тус шагнуулахаар санал, тодорхойлолтыг хүргүүлсэн.

“Бүртгэлийн ажилтны үйлчилгээний стандарт”-ын дагуу албан хаагчдын хувцаслалт, ажлын үнэмлэх, энгэрийн тэмдгийг шинэчлэн, стандартыг хэрэгжүүлж ажиллалаа.




### ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Дорнод гурил” ХХК-аас зохион байгуулсан Эх хэлээ хайрлан хамгаалж, үндэсний бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэхийг уриалан “Эх хэлээ эрхэмлэе” монгол бичгийн уралдаанд улсын бүртгэгч Д.Ууганчимэг, Г.Аззаяа, Г.Нарантуяа нар хамт олноо төлөөлөн оролцож, багаараа “ГУТГААР” байранд орж, өргөмжлөл бэлэг дурсгалын зүйлээр шагнагдав.



Үндэсний бичгийг сурах эрмэлзэл төрүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Үндэсний бичгийн цэвэр бичигтэн” шалгаруулах уралдааныг албан хаагчдын дунд зохион байгуулж улсын бүртгэгч Д.Ууганчимэг “ТЭРГҮҮН” байранд шалгарав.





Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 60 дугаар зарлигаар 2019-2020 оныг “Хүүхдийн хөгжил хамгааллын жил” болгон зарласантай холбогдуулан бага насны хүүхэдтэй эцэг, эхчүүдийн ая тухтай үйлчилгээ авах, хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүднээс хүүхдийн өрөөг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан тохижуулав.



Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн хөл хорио тогтоосон хугацаанд чиг үүргийнхээ хүрээнд албан хаагчдыг хуваарь гарган 24 цагийн ээлжийн жижүүрийн үүрэг гүйцэтгэж, аймгийн Онцгой комиссоос ирүүлсэн 1878 иргэний хаягийн мэдээллийн судалгааг гарган хамтран ажиллав.

Мөн аймгийн Онцгой комиссын зөвшөөрлөөр аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран шинээр төрсөн 79 хүүхдийн судалгааг гарган, иргэдтэй утсаар холбогдож зөвлөгөө мэдээллийг хүргэн, төрсний бүртгэлийг бүртгэж баталгаажуулсан.

Монгол Улсад бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ойг угтан [#ТАНД\\_БАЯРЛАЛАА\\_80\\_ЖИЛ](#) аяныг эхлүүлж, дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.



Монголчуудын үндэсний бахархал, Монголын ард түмний оюуны соёлын давтагдашгүй өв болох үндэсний бичгийг уламжлан дээдлэх, сурталчлан дэлгэрүүлэх их үйлсэд хувь нэмэр оруулах нь иргэн, хуулийн этгээд нэг бүрийн хичээл зүтгэлээс хамаарах тул байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаягийг үйлчилгээний стандартад нийцүүлэн “ХОС БИЧИГ”-ээр бичиж шинэчлэв.



Бүртгэлийн байгууллагын он цагийн хэлхээс, онцлогийг илтгэсэн иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хэрэглэгдэхүүн болох тухайн он жилүүдийн гэрчилгээ, холбогдох бичиг баримтаар “ТҮҮХЭН БИЧИГ БАРИМТ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЗЭСГЭЛЭН”-г дэлгэн иргэдэд сурталчлан таниулав.






Хүний амьдралын аз жаргал, баяр баясгалантай мөчүүдийн нэг бол гэрлэх ёслол, гэрлэлтийн баталгаа юм. Ирээдүйн амьдралаа холбож, гэрлэлтээ бүртгүүлж буй бүх хосууддаа зориулан "ГЭРЛЭХ ЁСЛОЛ"-ын буланг санаачлан хэрэгжүүлж аймгийн бүх сумд гэрлэх ёслолын өргөө болон булантай болж, иргэдийн талархлыг хүлээлээ.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Улсын бүртгэлийн байгууллагын иргэдэд үйлчлэх үйлчилгээний чанар хүртээмжийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зорилгоор нийгмийн сүлжээнд 10 асуулт бүхий “СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА”-г явуулахад 351 иргэн хамрагдсны 51.3 хувь нь 20-39 насны, 75.1 хувь нь эмэгтэй, 63.5 хувь нь бакалаврын зэрэгтэй иргэд эзэлж байна. Судалгааны агуулгаас авч үзвэл улсын бүртгэлийн байгууллагын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж буй өнөөгийн байдал, албан хаагчдын мэдлэг, ур чадвар эерэг буюу 50 хувиас дээш үзүүлэлттэй гарсан байна. Иргэд бүртгэлийн үйлчилгээний мэдээ, мэдээллийг улсын бүртгэгчээс гадна цахим орчноос авдаг гэж хариулсан байна.



**Дорнод аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс**  
Posted by Гэрэлцогт Алтанцогтын  
Nov 2 · 🌐

#САНАЛ\_АСУУЛГА

ТАНД ШИНЭ САР, ШИНЭ 7 ХОНОГИЙН МЭНД ХҮРГЭЕ.



УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ИРГЭДЭД ҮЙЛЧЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛЫГ ТОДОРХОЙЛОХОД ЭНЭХҮҮ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ЗОРИЛГО ОРШИНО.

Та дараах линкээр орж, судалгаанд хамрагдаж, бидний ажилд тусална уу.  
#ТАНД\_БАЯРЛАЛАА\_80\_ЖИЛ

[https://docs.google.com/forms/d/e/1FAIpQLSdLezpqQ\\_oa970CY2h9DarmxGWvap4jRgQ55A121jSyD6QP8Q/formResponse](https://docs.google.com/forms/d/e/1FAIpQLSdLezpqQ_oa970CY2h9DarmxGWvap4jRgQ55A121jSyD6QP8Q/formResponse)

✓ Иргэдэд ойр бүртгэлийн цахим үйлчилгээ  
Нээлттэй утас 98-970-970

DOCS.GOOGLE.COM  
ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН СЭТГЭЛ  
ХАНАМЖИЙН СУДАЛГАА  
Сэтгэл ханамжийг тодорхойлох судалгааны...



Иргэний улсын бүртгэлийн архивт өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан “ДОТООД ЗАСВАР”-ын ажлыг хийв.



Орон нутгийн төсвөөс 2 000 000 төгрөгийг шийдвэрлүүлж, иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын шүүгээг УБЕГ-аас татан авч стандартын дагуу “НЯГТАРШУУЛСАН ШҮҮГЭЭ”-гээр жигдрүүлэв.



Бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандартад нийцүүлэн “Бид Дорнод аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс”-ийнхэн уриан дор албан хаагчдыг “ДҮРЭМТ ХУВЦАС”-аар ижилслээ.



ГУРАВ. СОНГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН  
БЭЛТГЭЛ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД:**

- Иргэний улсын бүртгэлийн газраас 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн дотоод албан бичгээр ирүүлсэн үүрэг, даалгаврын дагуу Дорнод аймгийн хэмжээнд ижил, овог нэртэй бүртгэгдсэн 100 иргэний мэдээллийг иргэний улсын бүртгэлийн онлайн сан, лавлагааны программтай тулган нягтлан шалгаж ижил овог, нэртэй зөрчилгүй 33 иргэн, 2 регистрийн дугаартай 67 иргэн байсан бөгөөд 2 регисрийн дугаар олгогдсон 67 иргэний буруу олгогдсон регистрийн дугаарыг хүчингүй болгох Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулж ИУБГ-т хүргүүлэн зөрчлийг арилгуулсан. Илтгэх хуудсыг цахим шуудангаар хүргүүлсэн.

- Дорнод аймгийн хэмжээнд 1 хаягт 10 ба түүнээс дээш сонгогч бүртгэгдсэн 1056 иргэн, тодорхойгүй хаягтай 353 иргэн байх бөгөөд эдгээр иргэдийн хаягийн бүртгэлийг багийн дарга нартай хамтран зохион байгуулж, зарим иргэдтэй биечлэн уулзаж хаягийн бүртгэлийн зөрчлийг арилгах, мөн хаягийн бүртгэлээ цэгцлэхгүй тохиолдолд ямар үр дагавар гарах талаар, зөвлөгөө өгч, илтгэх хуудсыг ИУБГ-т цахим шуудангаар хүргүүлсэн.

Д/д	Нэг хаягт 10 ба түүнээс дээш сонгогч бүртгэгдсэн иргэний тоо	Үүнээс				
		Үндсэн хаягандаа байгаа	Хаягийн зөрчил арилгасан	Үндсэн хаягандаа байгаа боловч өөр хаягт амьдардаг	Нас барсан	Хаягт тодорхойгүй /холбогдох боломжгүй байгаа/
1	1056	800	50	166	3	37

Д/д	Тодорхойгүй хаягтай иргэн	Үүнээс давхар бүртгэгдсэн	Шалгах шаардлагатай үндсэн нэр	Үүнээс	
				Үүнээс зөрчил арилгасан	Үлдэгдэл
1	353	154	199	106	93



1

УБЕГ-ын даргын 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр баталсан “МУИХ-ын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө”

Хэлтсийн даргын 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн “МУИХ-ын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 22 заалт бүхий дэд төлөвлөгөө”-г боловсруулан, батлуулж хэрэгжилтийг ханган ажиллав.

2

- МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт  
- УБЕГ-ын даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/126 тоот тушаал  
- УБЕГ-ын 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 5/850 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл

Хэлтсийн даргын 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 110 тоот албан бичгээр хүргүүлсэн зөвлөмж

Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 17.00 цагт зогсоож, 24.00 цагт иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд баталгаажуулж дуусгасан.

3

МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д заасны дагуу аймгийн 14 сумын 72 хэсгийн "Сонгуулийн хэсэг байгуулсан" тухай тогтоолыг хүлээн авсан.

МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д заасны дагуу 14 сумын 72 хэсгийн хорооны тогтоолыг нэгтгэн, эх хувийг [www.election.gasr.mn](http://www.election.gasr.mn) сонгуулийн программд оруулсан.

МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д заасны дагуу 14 сумын 72 хэсгийн хорооны тогтоолыг нэгтгэн, эх хувиар ИУБГ-т хүргүүлсэн.

4

Мэдээлэл технологийн газраас тус аймгийн 72 хэсгийн 52271 сонгуулийн эрх бүхий иргэнд хэсэг оноосон бөгөөд үлдсэн 650 иргэний хаягийн мэдээллийг нягтлан, тулган шалгаж хэсэг оноосон.

Дорнод аймгийн нийт 52921 сонгуулийн насны иргэний байнга оршин суух хаягийн бүртгэл, овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр ижил, регистрийн дугаар давхардсан байж болзошгүй 67 сонгогчийн бүртгэлийг нягтлан шалгахад зөрчил илрээгүй.

ИУБГ-аас 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 5/3846 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хүрээнд ИУБ-ийн цахим сан дахь "Санал авах байрны бүртгэл" цэснээс 72 сонгуулийн хэсэгт хамаарах санал авах байр болон хэсгийн төв, түүнд хамаарах 13855 хаягийн мэдээллийг сумын ИТХТ-ийн хүчин төгөлдөр тогтоолтой нэг бүрчлэн тулгаж илтгэх хуудсыг ИУБГ-т цахим шувлангаар хураалтсан.

ИУБГ-аас 2020 оны 05 дугаар сарын 21-ний өдөр дотоод албан бичгээр ирүүлсэн үүрэг даалгаврын дагуу тус аймгийн 11 хэсэгт хамаарах 154 иргэний хэсэг оноолт буруу, ИТХТ-ийн тогтоол нь election систем болон онлайн сантай зөрж байна гэсэн зөрчил илэрсэн бөгөөд үүнийг нягтлан шалгаж илтгэх хуудсыг ИУБГ-т цахим шуудангаар хүргүүлсэн.

5

Дорнод аймаг дахь Тагнуулын газраас ирүүлсэн 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 35/109 тоот албан бичгээр ирсэн төрийн нууцтай харьцах зөвшөөрлийн дагуу 83 итгэмжлэгдсэн ажилтнуудад гэрээ байгуулан, нууцын баталгаа гаргуулан авах ажлыг зохион байгуулсан.


МУИХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн бэлтгэх ажлыг хангах зорилгоор 2020 оны 05 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд 72 хэсгийн хорооны дэргэд ажиллах 83 илтгэмжлэгдсэн ажилтанд эрх зүйн сургалтыг зохион байгуулсан.

6

МУИХ-ын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтыг /СНЖ/ хэвлэх эрхийг хэлтсийн даргын 2020 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 469 тоот албан бичгээр ИУБГ-т хүргүүлж, 4 улсын бүртгэгчид эрх авсан.

Аймгийн 72 хэсгийн СНЖ-д 53663 сонгогч бүртгэгдсэн байх бөгөөд үүнээс үндсэн 52120, Түр хасав төлөвтэй 1543 сонгогч бүртгэгдсэн. СНЖ хэвлэх ажиллагааг 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 11 цаг 42 минутад эхлүүлж 17 цаг 30 минутад 3 хувь хэвлэж дуусган, илтгэх хуудсыг ИУБГ-т цахим шуудангаар хүргүүлсэн.

14 сумын 72 хэсгийн СНЖ-ыг 2020 оны 05 дугаар сарын 28-31-ний өдрүүдэд 2 баг болон хуваагдан тагнуулын байгууллагатай хамтран хэсгийн хороодод амжилттай хүлээлгэн өгч, илтгэх хуудсыг ИУБГ-т цахимаар хүргүүлсэн.



УБЕГ-ын ИУБГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу 2020 оны 06 дугаар сарын 2-10 өдрүүдэд [www.election.gasr.mn](http://www.election.gasr.mn) программд СНЖ-д өөрчлөлтийг тусган, үүссэн лавлагааг хэвлэсэн

7

72 хэсгийн 83  
итгэмжлэгдсэн  
ажилтны хүлээн  
авсан 922  
лавлагааг  
хуулийн  
хугацаанд бүрэн  
хэвлэсэн.



8

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд даргын 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн баталсан нэгдсэн удирдамжийн дагуу МУИХ-ын 2020 оны ээлжит сонгуулиар ажиллах Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан ирц бүртгэлийн программын сургалт 2020 оны 06 дугаар сарын 12, 13 өдрүүдэд зохион байгуулагдсан.

СНЖ-д 922 лавлагаагаар өөрчлөлтийг тусган, СНЖ-ийг эцсийн байдлаар 3% хэвлэсэн.

Тус аймгийн 14 сумын 72 хэсгийн тоног төхөөрөмж, СНЖ-ийн 1 хувийг 2020 оны 06 дугаар сарын 17-19-ны өдрүүдэд хэсгийн хороодод хэсгийн хорооны ахлагч, цагдаагийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтануудад акт үйлдэн хүлээлгэн өгсөн.

9

МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.3-т заасны дагуу сонгуулийн санал авах ажиллагааг 2020 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 07:00 цагт эхлүүлж 22:00 цагт зогсоов.

10

Дорнод аймгийн 14 сумын 72 хэсэгт үндсэн сонгогч -52159, нийт -52236 сонгогч бүртгэгдснээс санал өгсөн хүний тоо 36106 буюу ирц 69.22 хувьтай байв.

Санал өгсөн байдлаар:

- Хурууны хээгээр 34463
- Регистрийн дугаараар-1145
- “Түр хасав” сэргээсэн-77
- Зөөврийн хайрцгаар-421

Хүйсээр

- Эрэгтэй -17502
- Эмэгтэй-18604

Насаар

- 18-25 нас -5650
- 26-40 нас -12541
- 41-55 нас – 10327
- 56 ба түүнээс дээш -7588

11

2020 оны 06 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд сонгуулийн ирц бүртгэлийн тоног төхөөрөмж болон СНЖ, ирцийн мэдээ, тайлангуудыг акт үйлдэн хүлээн авч, аймгийн Тагнуулын байранд хамгаалтан дор хадгалуулсан.

2020 оны 06 дугаар сарын 28-ны өдөр УБЕГ-т тоног төхөөрөмжийг илтгэх хуудсын хамт хүлээлгэн өгч ажиплаа.

**АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД:**

1

УБЕГ-ын даргын баталсан “АНСДИТХ-ын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг ханган ажилласан.

АНСДИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д заасны дагуу аймгийн 14 сумын 75 хэсгийн "Сонгуулийн хэсэг байгуулсан" тогтоолыг хүлээн авсан.

2

АНСДИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д заасны дагуу 14 сумын 75 хэсгийн хорооны тогтоолыг нэгтгэн, эх хувийг [www.election.gasr.mn](http://www.election.gasr.mn) сонгуулийн программд оруулсан.

АНСДИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д заасны дагуу 14 сумын 75 хэсгийн хорооны тогтоолыг нэгтгэн, эх хувиар ИУБГ-т хүргүүлсэн.

3

ИУБ-ийн цахим сан дахь "Санал авах байрны бүртгэл" цэснээс 75 сонгуулийн хэсэгт хамаарах санал авах байр болон хэсгийн төв, түүнд хамаарах 13526 хаягийн мэдээллийг сумын ИТХТ-ийн хүчин төгөлдөр тогтоолтой нэг бүрчлэн тулгаж илтгэх хуудсыг ИУБГ-т цахим шуудангаар хүргүүлсэн.

4

УБЕГ-ын ИУБГ-ын даргын 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 5/7130 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу 2020 оны 06 дугаар сарын 25-наас 2020 оны 08 дугаар сарын 14-ны өдөр хүртэлх хугацаанд иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргасан нийт 1124 иргэн, 437 хүүхдийн эх нотлох баримт бичиг бүрдүүлбэрийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сантай тулган нягтлан шалгаж тухай бүр баталгаажуулалтыг хийж ажилласан.

5

- АНСДИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалт  
- УБЕГ-ын даргын 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/1168 тоот тушаал  
- УБЕГ-ын ИУБГ-ын даргын 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 5/7130 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл

Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 17.00 цагт зогсоож, 24.00 минутад иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд баталгаажуулж дуусгасан.

2020 оны 08 дугаар сарын 15-ны өдөр 14 сумын шилжилт хөдөлгөөний бүртгэлийн 42 ширхэг дэвтэр болон 14917 ширхэг ИУБ-22 маягт үнэт цаасны дугаарыг тулган хүлээн авч акт үйлдэн, лацдаж хадгалах ажлыг зохион байгуулан ажилласан.

6

Дорнод аймаг дахь Тагнуулын газраас ирүүлсэн 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 35/158, 9 дүгээр сарын 09-ны өдрийн 35/160 тоот албан бичгээр ирсэн төрийн нууцтай харьцах зөвшөөрлийн дагуу 75 итгэмжлэгдсэн ажилтнуудад гэрээ байгуулан, нууцын баталгаа гаргуулан авах ажлыг зохион байгуулсан.


АНСДИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн бэлтгэх ажлыг хангах зорилгоор 2020 оны 09 дүгээр сарын 10-11 өдрүүдэд 75 хэсгийн хорооны дэргэд ажиллах 75 итгэмжлэгдсэн ажилтанд эрх зүйн сургалтыг зохион байгуулсан.

7

АНСДИТХ-ын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтыг /СНЖ/ хэвлэх эрхийг хэлтсийн даргын 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 732 тоот албан бичгээр ИУБГ-т хүргүүлж, 4 улсын бүртгэгчид эрх авсан.

Аймгийн 75 хэсгийн СНЖ-д 52805 сонгогч бүртгэгдсэн байх бөгөөд үүнээс үндсэн 51170, Түр хасав төлөвтэй 1635 сонгогч бүртгэгдсэн. СНЖ хэвлэх ажиллагааг 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 13 цаг 00 минутад эхлүүлж 17 цаг 20 минутад 3 хувь хэвлэж дуусган, илтгэх хуудсыг ИУБГ-т цахим шуудангаар хүргүүлсэн.

14 сумын 75 хэсгийн СНЖ-ыг 2020 оны 09 дүгээр сарын 18-20-ний өдрүүдэд 2 баг болон хуваагдан тагнуулын байгууллагатай хамтран хэсгийн хороодод амжилттай хүлээлгэн өгч, илтгэх хуудсыг ИУБГ-т цахимаар хүргүүлсэн.



1-р баг 2020 оны 09 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд хэлтсийн дарга Д.Оюунбаяраар ахлуулж, улсын ахлах бүртгэгч А.Наранчимэг нарын бүрэлдэхүүнтэйгээр Хэрлэн, Сэргэлэн, Цагаановоо, Баян-уул, Баяндун, Дашбалбар, Чулуунхороот, Гурванзагал, Чойбалсан сумын сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нарыг байлцуулан сонгогчдын нэрийн жагсаалтыг “СНЖ-т хүлээлцэх акт”-ын хамт хүлээлгэн өгсөн.



2-р баг 2020 оны 09 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд Хяналтын улсын байцаагч Л.Сугаррагчаагаар ахлуулж, улсын бүртгэгч Ц.Энхчимэг нарын бүрэлдэхүүнтэйгээр Баянтүмэн, Булган, Хөлөнбуйр, Матад, Халхгол сумын сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нарыг байлцуулан сонгогчийн нэрийн жагсаалтыг “СНЖ-т хүлээлцэх акт”-ын хамт хүлээлгэн өгсөн.



8

АНСДИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 20.9.1-20.9.5 дахь хэсэг, “АНСДИТХ-ын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх журам”-ын 3.5 дахь хэсэгт заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтад тусгагдсан 15ш өөрчлөлтийн лавлагааг /нас баралт-10, Иргэний бүртгэлтэй холбоотой өөрчлөлт – 5/ хэвлэж баталгаажуулсан.



9

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн баталсан нэгдсэн удирдамжийн дагуу АНСДИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулиар ажиллах Улсын бүртгэлийн байгууллагын 75 хэсгийн 75 итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан ирц бүртгэлийн программын сургалт 2020 оны 10 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулагдсан

СНЖ-д 58 лавлагаагаар өөрчлөлтийг тусган СНЖ-ийг эцсийн байдлаар 2% хэвлэсэн.

Тус аймгийн 14 сумын 75 хэсгийн тоног төхөөрөмж, СНЖ-ийн 1 хувийг 2020 оны 10 дугаар сарын 18-ны өдөр хэсгийн хороодод хэсгийн хорооны ахлагч, цагдаагийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтануудад акт үйлдэн хүлээлгэн өгсөн.

10

АНСДИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.3-т заасны дагуу сонгуулийн санал авах ажиллагааг 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 07:00 цагт эхлүүлж, мөн хуулийн 64 дүгээр зүйлийн 64.14-т заасны дагуу 20:00 минутад зогсоов.

11

Санал авах үйл ажиллагаа эхлэхэд 9-1-2, 9-1-5 дугаар хэсэгт принтер хэвлэхгүй, 9-1-4, 9-1-10 дугаар хэсэгт принтерийн хор бүдэг, 9-3-2 дугаар хэсэгт ирц бүртгэлийн программын он, сар, өдөр зөрүүтэй, 9-1-13 дугаар хэсэгт зөөврийн хайрцгаар санал өгсөн 19 сонгогчийн мэдээллийг оруулахдаа ирц бүртгэлийг сонгож оруулсан зөрчлүүд үүссэн бөгөөд тухай бүрт нь шийдвэрлэж ажилласан

Дорнод аймгийн 14 сумын 75 хэсэгт үндсэн сонгогч -51204, нийт -51247 сонгогч бүртгэгдснээс санал өгсөн хүний тоо 29366 буюу ирц 57.13 хувьтай байв.

Санал өгсөн байдлаар:

- Хурууны хээгээр 28081
- Регистрийн дугаараар-816
- “Түр хасав” сэргээсэн-43
- Зөөврийн хайрцгаар-426

Хүйсээр

- Эрэгтэй -13505
- Эмэгтэй-15861

Насаар

- 18-25 нас -2749
- 26-40 нас -10453
- 41-55 нас – 995
- 56 ба түүнээс дээш -6969

12

АНСДИТХ-ийн сонгуульд тус аймгийн 2 тойрогт санал тэнцснээр 2020 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Баяндун, Халхгол сумын тус бүр 1 хэсэгт нэмэлт сонгууль зарлагдаж ирц 57.3 хувьтайгаар амжилттай дууссан.

13

2020 оны 10 дугаар сарын 15-16, 25-ны өдрүүдэд сонгуулийн ирц бүртгэлийн тоног төхөөрөмж болон СНЖ, ирцийн мэдээ, тайлангуудыг акт үйлдэн хүлээн авч, аймгийн Тагнуулын байранд хамгаалтан дор хадгалуулсан.

14

2020 оны 10 дугаар сарын 28-ны өдөр УЕГ-т тоног төхөөрөмжийг илтгэх хуудсын хамт хүлээлгэн өгч ажиллалаа.

#### ДӨРӨВ. ХАМТЫН АЖИЛЛАГАА, СУРГАЛТ:

2020 онд хийж хэрэгжүүлэх ажил, үүрэгтэй холбоотойгоор Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга болон аймгийн Засаг даргатай “Гүйцэтгэлийн төлөвлөгөө” байгуулан, биелэлтийг ханган ажиллаж байна.



Төрийн байгууллагын ажлын уялдаа холбоог бэхжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газар, Тагнуулын зүүн бүс дахь газар, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Гадаадын иргэн, харьяатын газрын зүүн бүс дэх газар, Газрын харилцаа, хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, Татварын хэлтэс, Статистикийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Гэр бүл хүүхэд, залуучуудын газар, Эрүүл мэндийн газар, аймгийн Онцгой комисс зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж байна.



Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулсан "ЯТГАХ ТУСАМ НЯГТАЛ" аянд нэгдэн залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сэрэмжлүүлэг хийж иргэдийг уриалж ажиллав.



Дорнод аймгийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтсээс санаачлан, цахим орчинд идэвхитэй ажилладаг групп, админуудтай хамтран зохион байгуулсан "МЭДЭЭЛЛИЙГ ЭХ СУРВАЛЖААС НЬ" арга хэмжээнд оролцож байгууллагын цаг үеийн байдалтай холбоотой мэдээллийг хүргэв. Дан ганц сонин сэтгүүл, тв радиогоор бус сошиал орчинд мэдээлэл түгээх нь илүү хүртээмжтэй болсон одоо цагт нөхцөл байдлаа мэдэрч ажиллах нь цаг үеийн шаардлага болоод байна. Мэдээллийг эх сурвалжаас нь буюу үнэн бодит байдал хамгаас чухал талаар харилцан ярилцаж, санал бодлоо солилцов.



Корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх, иргэдийнхээ эрүүл мэнд, аюулгүй байдлыг сахин хамгаалах зорилгоор Дорнод аймгийн Онцгой комиссын шийдвэр, аймгийн Засаг даргын А/266 дугаар захирамжийн дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид, аймгийн Биеийн тамир спортын газартай хамтран Хэрлэн сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 04 дүгээр сарын 30-ны өдрийг



## ДОРНОД АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

хүртэл ажиллах эргүүлийн хуваарь гарган баталж, албан хаагчдыг хуваарийн дагуу 10:00-20:00 цагийн хооронд эргүүл хяналтыг хийлгүүлэв.


Эргүүл хяналтын хугацаанд иргэдэд амны хаалтаа зүүж, бага насны хүүхдүүддээ үлгэрлэн тогтмол гарын ариун цэврээ сахиж, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд олноор бөөгнөрөл үүсгэхгүй байж өөрийгөөболон бусдыг халдвараас хамгаалан **“ЭЛЭГ БҮТЭН-ЭРҮҮЛ ЭНХ”** амьдралын төлөө **ХАМТДАА** хичээцгээе уриан дор аймгийн Эрүүл мэндийн газраас ирүүлсэн зөвлөмжийголшруулан иргэдэд тараан ажиллалаа.



Covid-19 өвчний тархалт өдөр өдрөөр нэмэгдэж байгаа цаг үед хариуцлагатай байж, маскаа зүүхийг уриалан **“ХАЙРТАЙ ХҮМҮҮСИЙНХЭЭ ТӨЛӨӨ ХАМТДАА ХИЧЭЭЦГЭЭ”** чөллэнжийг санаачлан Хэнтий аймаг, Дорноговь аймаг, Төв аймаг, Говьсүмбэр аймаг, Чингэлтэй дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олныг нэгдэхийг уриалав. Уг уриалга 14 146 хэрэглэгчийн хандалт авсан.



Фэйсбүүкийн профайл зургийг “БИ АМНЫ ХААЛТАА ТОГТМОЛ ЗҮҮДЭГ” мессэж бүхий амны хаалттай профайл зургийг оруулж, 10 найзаа чэллэнжид дуудах аянг өрнүүлж ажиллав.



“Хөгжлийн шийдэл” төрийн бус байгууллагаас зохион байгуулсан жижиг дунд бизнесүүдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн сайн засаглал, хариуцлага, ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн уулзалтад оролцов.



#### СУРГАЛТ:

- Хэлтсийн хэмжээнд 22 нэр төрлийн сургалт зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгаснаас жилийн эцсийн байдлаар нийт 37 сургалт /бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 14 сургалт, албан хаагчдийн хандлага, хариуцлага болон бусад чиглэлээр 4, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарсан 6, сонгуулийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр 13 / зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 201 албан хаагч хамрагдахаас 201 албан хаагч хамрагдаж ирц 100 хувь, төрийн байгууллагын 316 албан хаагч хамрагдсан байна.

- Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан 19 удаагийн онлайн сургалтанд /бүртгэлийн чиглэлээр-8, хяналт, шалгалтын чиглэлээр-2, сонгууль- 4, бусад -

5, давхардсан тоогоор нийт 68 албан хаагчид бүрэн хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн.

### 2. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САНГААС ХЭВЛЭГДСЭН СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТЫГ ТАНИЛЦУУЛАХ, ТҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

АЙМАГ, НИЙСЭГД, СУМ, ДУРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨНГӨДИЙН ХУУРИЙН СОНГОГЧДИЙН СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ

№	Эх сурвалж	Өргөжин нэмэлт	СОНГОГЧИЙН					Сонгогчид мэдсэн сонгогчийн хувиар	Тайлбар
			1	2	3	4	5		
1	Иргэдийн	10/06/2019	25	10	10	10	10	10	
2	Иргэдийн	10/06/2019	25	10	10	10	10	10	
3	Иргэдийн	10/06/2019	25	10	10	10	10	10	
4	Иргэдийн	10/06/2019	25	10	10	10	10	10	
5	Иргэдийн	10/06/2019	25	10	10	10	10	10	
6	Иргэдийн	10/06/2019	25	10	10	10	10	10	
7	Иргэдийн	10/06/2019	25	10	10	10	10	10	
8	Иргэдийн	10/06/2019	25	10	10	10	10	10	
9	Иргэдийн	10/06/2019	25	10	10	10	10	10	
10	Иргэдийн	10/06/2019	25	10	10	10	10	10	
11	Иргэдийн	10/06/2019	25	10	10	10	10	10	
12	Иргэдийн	10/06/2019	25	10	10	10	10	10	
13	Иргэдийн	10/06/2019	25	10	10	10	10	10	
14	Иргэдийн	10/06/2019	25	10	10	10	10	10	


САНАЛ АВАХ ӨДРӨӨС 25-ААС ДООШГУЙ ХОНОГИЙН ӨМНӨ  
2020.09.17-19

СОНГУУЛИЙН ХЭСГИЙН ХОРОО 1%

УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ИТГЭМЖЛЭГДСЭН АЖИЛТАН 1%

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС 1%


- Хэлтсийн сургалтын төлөвлөгөөний дагуу улсын бүртгэгч нарт улсын бүртгэлийн талаар анхаарах асуудал, цаг ашиглалт, сарын тоон мэдээ, үнэт цаасны тайланг гаргахад анхаарах асуудал, Төрийн албан хаагчийн манлайлал, харилцааны ур чадварын талаар, иргэний улсын бүртгэлийн шинэ программын туршилт зэрэг сэдэвт онлайн сургалт тус тус хийсэн. Мөн 3 удаагийн зөвлөмжийг хүргүүлсэн. Мөн шинээр ажилд орсон албан хаагчийг ажлын байран дээр дадлагажуулах сургалтыг 1 удаа зохион байгууллаа. Сургалтанд 82 албан хаагч хамрагдсан.



- Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран Эрдэс таван толгойн хувьцааны данс нээх тухай, Хүүхдүүдээ цахим хичээлд хамруулах тухай, Төрийн албаны удирдах албан тушаалтанд зориулсан жендэр, Төрийн байгууллагын стратеги төлөвлөлт хийх арга зүй, Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Ахлах түшмэлийн зэрэг дэв нэмэгдүүлэх сэдэвт 6 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 57 албан хаагч хамрагдсан.



• Монгол Улсын Их Хурлын сонгууль, Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд хэсгийн хорооны дэргэд ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан сургалтыг онлайнаар 4, танхимаар 3 удаа зохион байгуулж, илтгэх хуудсыг холбогдох газарт тухай бүр хүргүүлэн ажиллалаа. Сургалтад давхардсан тоогоор 316 итгэмжлэгдсэн ажилтан хамрагдав.




Сургалтыг ЭМЯ-наас ирүүлсэн чиглэл зөвлөмжийн дагуу коронавирус /ковид-19/-ийн халдвараас урьдчилан сэргийлж сургалт зохион байгуулах танхимыг зориулалтын бодисоор ариутган, сургалт эхлэхээс өмнө хүн нэг бүрийн биеийн дулааны хэмийг шалгаж, маск, бээлийгээр ханган ариутгалын бодисоор ариутган, итгэмжлэгдсэн ажилтнуудыг 1,5 метр зайг бариулан ажиллав.



#### ТАВ. ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

Улсын бүртгэлийн ерөнхий газар болон хэлтсээс зохион байгуулсан үйл ажиллагаа, мэдээ мэдээллийг цаг тухай бүрт нь [www.dornod.burtgel.gov.mn](http://www.dornod.burtgel.gov.mn), [www.facebook.com/Ubh.dornod](https://www.facebook.com/Ubh.dornod) цахим хуудаснаа нийтлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд цаг үе, үйл явдалтай холбоотойгоор 91, иргэдийн эрх зүйн боловсролыг сайжруулах чиглэлээр цахим хуудсаар хууль сурталчлах 142 баннер, зурагт мэдээлэл байршуулж, цахим хуудасны сэтгэгдэл, захиагаар хандсан 173 иргэнд зохих мэдээлэл, зөвлөгөөг хүргэж ажилласан. [www.facebook.com/Ubh.dornod](https://www.facebook.com/Ubh.dornod) фэйсбүүк хуудас нь 4213 дэмжигчидтэй байна.





Хэлтсийн вэб сайтыг шинэчлэх ажлын хүрээнд [www.ubh.dd.gov.mn](http://www.ubh.dd.gov.mn) цахим хуудсыг [www.dornod.burtgel.gov.mn](http://www.dornod.burtgel.gov.mn) цахим хуудас болгон дараах бүтэц, агуулгатайгаар шинэчлэв.

Үүнд:

#### 1.1. ТАНИЛЦУУЛГА

- Нэгжийн бүтэц
- Албан тушаалтан, утас

#### 1.2. МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

- Текст
- Видео мэдээ

#### 1.3. ИЛ ТОД БАЙДАЛ

- Шилэн данс
- Санхүүгийн ил тод байдал
- Хурал, сургалт, семинар, хэлэлцүүлгийн зар
- Жил, улирлын тайлан

#### 1.4. ХЭРЭГЛЭГЧ

- Байгууллагын үйлчилгээний стандарт
- Өргөдөл, гомдол шийдвэрлэсэн байдал
- Нээлттэй ажлын байрны зар
- Сар бүрийн тоон мэдээлэл
- Түгээмэл асуулт, хариулт

### 1.5. ХОЛБОО БАРИХ

- Байгууллагын албан ёсны хаяг, утас, и-шуудан
- Ажиллах цагийн хуваарь
- Иргэдийг хүлээж авах цагийн хуваарь
- Өргөдөл, гомдол хүлээн авах цахим хаяг, утас

### 1.6. БИДНИЙ ТУХАЙ

- Аймгийн тухай ерөнхий болон тоон мэдээлэл

### 1.7 ТҮҮХ СОЁЛ

- Аймгийн түүх болон дурсгалт газар
- Аялал жуулчлал


### 1.8. ГАЗРЫН ЗУРАГ

- Аймгийн газрын зураг
- Аймаг, нийслэл, сум хоорондын зай, км

### 1.9. ГАЛЛЕРЕЙ

- Аймгийн дурсгалт газрын фото зургийн цомог

Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор үйлчилгээний танхимд улсын бүртгэгч нарын ажил үүргийн хуваарь, мэдүүлэг хүлээн авах цонхонд үйлчилгээний дансны дугаар шинэчлэн байршуулав.





Иргэн, хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор “Иргэний цахим үнэмлэх хэрхэн захиалах”, “Иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэл зогсоох тухай”, “Гэрлэлт бүртгэл болон гэрлэлт цуцлалт”, “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчөө бүртгүүлэх” сэдвээр орон нутгийн D1, Мижиг телевизүүдэд мэдээллүүдийг хийв.

## ДОРНОД АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН




Аж ахуй нэгж байгууллагын удирдлагуудыг зөвлөгөө, мэдээ, мэдээллээр хангах өгөх зорилгоор **“ДОРНОД АЙМГИЙН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА”** цахим хуудсыг үргэлжлүүлэн ажиллуулж байна.




Улсын бүртгэлийн хэлтсээр үйлчлүүлж буй иргэн бүрийн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэж, үйлчилгээний соёл, сэтгэл ханамжийн баталгааг өндөржүүлж, харилцааны болон үйлчилгээний зөрчилгүй хамт олон болох зорилгоор **“УГТАХ, ЛАВЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ”**-г ажиллуулж хэвшсэн бөгөөд тайлант хугацаанд 1304 иргэнд зөвлөгөө, мэдээлэл хүргэн ажиллав.




Улсын бүртгэлийн багц хуулийн үзэл санааг хэрэгжүүлж, бүртгэлийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, хүртээмжтэй хүргэхээс гадна иргэдийн талархалыг хүлээсэн **“ИРГЭН ТАНЫ ГЭРТ, ГАРТ ҮЙЛЧИЛГЭЭ”**-г үргэлжлүүлэн ажиллуулж байна. Энэхүү үйлчилгээгээр өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гадаад паспорт, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, цахим иргэний үнэмлэх, лавлагаа зэргийг гэрт нь хүргэн өгдөг бөгөөд тайлант хугацаанд 59 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.



Интернет орчинг идэвхитэй ашигладаг үйлчлүүлэгч иргэд байгууллагын [www.ubh.dd.gov.mn](http://www.ubh.dd.gov.mn) цахим сайтын **“ОНЛАЙН ЛАВЛАГААНЫ СИСТЕМ”**-ээр гадаад паспорт, цахим иргэний үнэмлэх, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ зэргийг хэвлэгдсэн эсэхийг регистрийн дугаараараа шалгах боломж бүрдсэн бөгөөд тайлант хугацаанд 1125 иргэний мэдээллийг тус системд шивж оруулав.



Иргэдийн хэвлэгдэн ирсэн гадаад паспорт, цахим иргэний үнэмлэхийг **“МЕССЕЖ ҮЙЛЧИЛГЭЭ”**-ээр мэдээллийг хүргэн ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд 1107 иргэд мессеж мэдээллийг хүргэн ажиллав.



Байгууллагын “**НЭЭЛТТЭЙ УТАС 98-970-970**” тусгай дугаарыг ажлын өдрүүдэд хариуцан ажиллах албан хаагчдын хуваарь гарган ажиллууллаа. Иргэд бүртгэлийн үйл ажиллагаа болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бүхий л төрлийн мэдээллийг авах боломжтой бөгөөд тайлант хугацаанд 917 дуудлага хүлээн авсан байна.



**ИРГЭН ТА МАНАЙ БАЙГУУЛЛАГЫН  
ЛАВЛАХ УТАС  
98-970-970**

**ДУГААРТ ХОЛБОГДОЖ ИРГЭНИЙ, ЭД  
ХӨРӨНГИЙН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР  
МЭДЭЭЛЭЛ АВАХ БОЛОМЖТОЙ.**

Дорнод аймаг дахь улсын бүртгэлийн хэлтэс

Үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамж авах хэлбэрийг боловсронгуй болгох, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх зорилгоор Төрийн банк, Голомт банктай хамтран “**ПОС ТЕРМИНАЛ**” машин ажиллуулж байгаа бөгөөд тайлант хугацаанд 905 иргэнд үйлчилсэн.



## ИРГЭН ТА

- ✓ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл
- ✓ Иргэний улсын бүртгэл

Үйлчилгээний төлбөрөө **ПОС ТЕРМИНАЛ МАШИН** -аар төлөх боломжтой.

*Иргэнд ойр бүртгэлийн  
Цахим үйлчилгээ*

Улсын бүртгэлийн үйлчилгээний хураамжийг "Цахим\_төлбөрийн\_баримтын\_систем"-ээр төлөх боломжтойг иргэдэд сурталчлан ажиллаж, тайлант хугацаанд 832 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.



## ИРГЭН ТА

- ✓ Иргэний улсын бүртгэл
- ✓ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл
- ✓ Хуулийн этгээдийн улсын бүртгэл


Үйлчилгээний төлбөрөө **Е-ВАРИМТ** аппликейшн ашиглан интернэт банкаар төлөх боломжтой.

**105**  
БҮРТГЭЛИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТЭС

Иргэнд ойр бүртгэлийн  
Цахим үйлчилгээ

Коронавирус /ковид-19/ цар тахлын хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан иргэдийн цаг хугацааг хэмнэх зорилгоор 6 дугаар сарын 7 хоног бүрийн Даваа гаригийг **"НЭЭЛТТЭЙ ЦАХИМ ӨДӨР"** болгон зарлаж, 4 удаагийн өдөрлөгөөр 78 асуултад хариулж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав.



Дорнод аймаг дахь  
Улсын бүртгэлийн хэлтэс

“ Иргэнд ойр бүртгэлийн ~ цахим үйлчилгээ ”


## НЭЭЛТТЭЙ ЦАХИМ ӨДӨР

/ 2020 оны 06 сар /

**ИРГЭН ТАНД:**

**?** Улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой ямар асуулт байна ?

- Иргэний улсын бүртгэл
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл
- Хуулийн этгээдийн улсын бүртгэл



Нээлттэй утас: 98-970-970

Цахим хуудас: [ubh.dd.gov.mn](http://ubh.dd.gov.mn), [fb.com/ubh.dornod/](https://fb.com/ubh.dornod/)

Мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс УБЕГ-ын [www.burtgel.gov.mn](http://www.burtgel.gov.mn), аймгийн Засаг даргын Тамгын газрын [www.dornod.burtgel.gov.mn](http://www.dornod.burtgel.gov.mn) хуудсанд тавигдсан мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудсанд хуваалцаж, иргэдийг мэдээ мэдээллээр хангав.

Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан зурагт хуудас бүхий баннерийг интернэт орчинд байршуулснаар иргэдийг өөрийн биеэр ирэлгүйгээр гэрээсээ байгууллагын нээлттэй утас, вэб, пэйж хуудас руу хандан зөвлөгөө мэдээлэл авах боломжийг бүрдүүлж ажиллалаа.



ИРГЭН ТА МАНАЙ БАЙГУУЛЛАГЫН  
“ДОРНОД АЙМАГ ДАХЬ УЛСЫН  
БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС” FACEBOOK  
ХУУДСАНД НЭГДЭЖ

ИРГЭНИЙ, ЭД ХӨРӨНГИЙН, ХУУЛИЙН  
ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЧИГЛЭЛЭЭР ОНЛАЙНААР ЗӨВЛӨГӨӨ,  
МЭДЭЭЛЭЛ АВАХ БОЛОМЖТОЙ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

## ИРГЭН ТА

Олон улсад гарсан **КОРОНАВИРУС**-ын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор Иргэн таныг олон нийтийн газраар шаардлагагүй тохиолдолд явахгүй байдлыг анхааруулж байна.

Иймд Та бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой мэдээллийг завчвал өөрийн биеэр ирэх шаардлагагүйгээр доорх НЭЭЛТТЭЙ УТАС болон ЦАХИМ хуудсаар дамжуулан авах боломжтой.

НЭЭЛТТЭЙ УТАС: **98-970-970**

ЦАХИМ ХУУДАС: **[www.ubh.dd.gov.mn](http://www.ubh.dd.gov.mn)**

ФЭЙСБҮҮК: **Дорнод аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс /Онлайн чатаар зөвлөгөө авах /**

МОН ЛАВЛАГАА МЭДЭЭЛЛИЙГ  
**[WWW.BURTSEL.MN](http://WWW.BURTSEL.MN)** САЙТААС  
ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ АВАХ БОЛОМЖТОЙ.



Байгууллагын ил тод нээлттэй байдлыг ханган ажиллах үүднээс байгууллагын ухаалаг самбарт мэдээллийг тогтмол болон байнга шинэчлэн байршуулан ажиллаж байна.




Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хөл хорио тогтоосон хугацаанд албан хаагч бүр "ТА АСУУ БИД ЗӨВЛӨӨ" уриалга бүхий профайл зургийг оруулан иргэдийг зөвлөл мэдээллээр хангаж ажиллав.





ЗУРГАА. БҮРТГЭЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ, ХАРЬЦУУЛАЛТ  
БИЧИГ ХЭРГИЙН ЭРГЭЛТ



БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОО  
/2016-2020 он/

Он	Иргэний улсын бүртгэл	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл	Хуулийн этгээдийн улсын бүртгэл	Архив	Нийт
2016 он	4629	1281	220	225	6355
2017 он	7000	615	147	384	8146
2018 он	5060	1200	350	180	6790
2019 он	3105	550	180	165	4000
2020 он	15722	400	158	100	16380

БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ШАЛГАЛТААР  
ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ /2016-2020 он/

Он	Иргэний улсын бүртгэл	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл	Хуулийн этгээдийн улсын бүртгэл	Архив	Нийт
2016 он	21	19	9	1	50
2017 он	108	30	12	2	152
2018 он	39	10	10	1	60
2019 он	34	2	2	0	38
2020 он	20	2	2	0	24

Хялбаршуулсан журмаар 740 иргэнд торгууль, шийтгэл ногдуулсан.

30 иргэний Үндэсний энгийн гадаад паспортыг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд хүчингүй болгосон.


ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ  
/2016-2020 ОН/

Он	Иргэний улсын бүртгэл	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл	Хуулийн этгээдийн улсын бүртгэл	Нийт
2016 он	23	0	0	23
2017 он	41	3	5	49
2018 он	35	7	2	44
2019 он	30	23	7	60
2020 он	88	49	4	141



ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр нийт 17355 бүртгэл бүртгэгдсэн. Үүнийг ангилвал:






Иргэний улсын бүртгэлийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 5/3701 тоот албан бичиг, 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотоод албан бичиг, мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/1290 тоот тушаалын дагуу иргэний улсын бүртгэлийн системийн шинэчилсэн программд туршилт хийж, туршилтын явцад гарч байсан алдаа дутагдлын талаар 2020 оны 05 дугаар сарын 04, 2020 оны 05 дугаар сарын 15, 2020 оны 07 дугаар сарын 23, 2020 оны 09 дүгээр сарын 16, 2020 оны 10 дугаар сарын 23-ний өдрүүдэд тус тус 5 удаагийн саналыг ИУБГ-т цахим шуудангаар хүргүүлсэн.

Е баримт төлбөрийн системийг ашиглан 1149 иргэн үйлчилгээний хураамж тушааж, 100 хувь баталгаажуулсан.




### ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ


Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл




Газар өмчлөх эрхийн улсын бүртгэл




Гэрээний эрхийн бүртгэлийн тоо




Барьцааны гэрээ, барьцааны эрх дуусгавар болгох бүртгэл



Бусад бүртгэл



Лавлагаа, хуулбар өгөх



Нийт бүртгэсэн бүртгэлийн **21.7%** хувийг газар өмчлөх болон газар эзэмших эрхийн бүртгэл, **5.3%** хувийг газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл, **44.2%** хувийг барьцааны гэрээ, **16.1%** хувийг өмчлөх эрх шилжих гэрээ, **8.7%** хувийг лавлагаа хуулбар, **4%** хувийг гэрээ хэлцлээс бусад эрхийн улсын бүртгэл эзэлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн эрх түдгэлзүүлсэн тухай 18 албан бичгээр 26 үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлж, эрх сэргээх тухай 15 албан бичгээр ирүүлсэн албан хүсэлтийг үндэслэн 20 үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг сэргээн ажиллав.

Монголын ипотекийн корпораци 2020 оны 20/22, 20/14-230, 20/06-19, 20/06-18, 20/08-18, 20/08-17 тоот албан бичгээр “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багц”-ыг тусгай тэмдэглэл хийж бүртгүүлэхийг хүссэн хүсэлтийг хүлээн авч худалдах, худалдан авах гэрээнд /ипотекийн зээл/ тусгагдсан 5 банкны 162 ширхэг эд хөрөнгөнд тусгай тэмдэглэл хийж, мэдээллийн санд бүртгэж ажиллав.


Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын тушаалаар 27 ширхэг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 11-ны өдрийн 8/7219 чиглэлийн дагуу хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 15 ширхэг нийт 42 ширхэг үрэгдүүлсэн үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг хүчингүй болгож дахин шинээр гэрчилгээ бичиж олгов.


Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг архивын хувийн хэргийн нотлох баримттай тулган шалгаж, Хяналтын улсын байцаагчийн 34 дүгнэлтээр 60 хувийн хэргийн мэдээллийн санд засвар өөрчлөлт оруулж, мэдээллийн санд баяжилт хийж ажиллалаа.



#### ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан аймгийн хэмжээнд эцсийн өмчлөгчөө бүртгүүлэх шаардлагатай 2090 аж ахуйн нэгжээс хүсэлт гаргасан 646 буюу 31%-ийг хууль тогтоомжийн дагуу бүртгэж баталгаажуулав.





**АРХИВ:**

**Иргэний улсын бүртгэлийн архив:**

Иргэний улсын бүртгэлийн архивт 165476 ширхэг ХААТР, ИУБ маягт хадгалагдаж байна. Тайлант хугацаанд 9522 иргэний улсын бүртгэлийн маягтууд, шилжин ирсэн 250 иргэний хувийн хэргийг архивд байршуулж, шилжин явсан 115 иргэний хувийн хэргийг харьяа орон нутагт нь хүргүүлэв.

Иргэний улсын бүртгэлийн архивт эмхлэх, цэгцлэх ажлыг шат дараатай гүйцэтгэж, хувийн хэргийн аюулгүй байдал хадгалалт хамгаалалтыг хангах сайжруулах зорилгоор хувийн хэргүүдийг цагаан толгойн үсгийн дарааллаар галиглаж 1500 зориулалтын бор хайрцагт нийт 67500 иргэний хувийн хэргийг байршуулж, хадгаламжийн санг үүсгээд байна.





**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архив:**

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт 39198 хувийн хэрэг хадгалагдаж байна. Үүнээс:

Газар өмчлөх-26378

Газар эзэмших 1205

Газар ашиглах-23

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө-11589

Хөдлөх хөрөнгө -3

**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архив:**

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивт 2377 аж ахуйн нэгж байгууллагын хувийн хэрэг хадгалагдаж байна. Үүнийг хэлбэр тус бүрээр нь харуулвал. Үүнд:

1. Улсын төсөвт үйлдвэрийн газар- 162
2. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар-15
3. Төрийн өмчит хувьцаат компани -1
4. Хувьцаат компани- 9
5. Хязгаарлагдмал хариуцлагатай компани- 1650
6. ХХК-Банк бус санхүүгийн байгууллага- 7
7. Аудит -1
8. Хадгаламж зээлийн хоршоо- 8
9. Хоршоо-73
10. Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл- 43
11. Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл- 42
12. Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл- 2
13. Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага -200
14. Гишүүдэд үйлчилдэг төрийн бус байгууллага- 62
15. Боловсрол сургалтын байгууллага- 3
16. Үйлдвэрчний эвлэлийн байгууллага-65
17. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл -2
18. Сан - 23
19. Шашин-9

Шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 118 төрийн бус байгууллагын хувийн хэрэг баримт материалууд архивт байршиж байна.


✚ Хуулийн этгээд улсын бүртгэл, эд хөрөнгийн улсын бүртгэлийн архивын тоон мэдээг сар бүрийн 25-ны өдрийн дотор гаргаж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архив, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын газарт хүргүүлэн ажилласан.


✚ Архивын өрөө тасалгааны аюулгүй байдал, хадгаламжийн нэгжийн бүрэн, бүтэн байдлыг камержуулалтын системийн тусламжтайгаар хянах нөхцлийг бүрдүүлсэн.

ДОЛОО. ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

Иргэн, хуулийн этгээдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан 1143 санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч тухай бүрт нь шийдвэрлэж хариу өгч ажилласан. Үүнийг ангилвал:

Хэлбэр	Тоо
Гомдол	2
Хүсэлт	24
Өргөдөл	183
Талархал	17
Зөвөлгөө өгсөн	917
Нийт	1143





### НАЙМ.САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР

Тус хэлтэс нь 2019 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Төрийн аудитын газарт хүргүүлэн санхүүгийн аудит хийлгэж, Төрийн аудитын газраас **“ИТГЭМЖЛЭЛ”** дүгнэлттэй үнэлэгдсэн.



Тайлант хугацаанд 406824,9 төгрөгийн төсөвтэйгээр үйл ажиллагаа явуулж 389953,9 төгрөгийн буюу 95.9% төсвийн гүйцэтгэлтэй, 16871.0 төгрөгийн буюу 4.1%-ийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсвийн хүрээнд мөнгөн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулах, төсвийн зардлыг бууруулах ажлын хүрээнд тайлант хугацаанд орон нутгийн аж ахуй нэгжүүдээс үнийн судалгаа явуулж, бичгийн цаас нэг бүрийг 4750 төгрөгөөр хямд, принтрийн хор нэг бүрийг 2000 төгрөгөөр хямдруулан авч бодит хэмнэлттэй ажиллав.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn), байгууллагын [www.ubh.dd.gov.mn](http://www.ubh.dd.gov.mn) сайтад тайлант хугацаанд Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангахаар 139 мэдээлэл байршуулахаас 139 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулан 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан.

### ЕС.ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР

“Ажлын тусгай горимын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-ний дагуу дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:

Эрүүл мэндийн зөвлөгөө, халдвараас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөмж бүхий сурталчилгааны зурагт хуудсыг ажлын байр, үйлчилгээний танхим, үйлчилгээ үзүүлж буй цонхонд байршуулав.



Байгууллагын үйлчилгээний заал болон өрөө, тасалгаа, коридорт халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж бүхий сурталчилгааны зурагт хуудсыг тогтмол шинэчлэн байршуулан ажиллаж байна.



Үйлчилгээний зааланд үйлчлүүлэгчдэд болон албан хаагчдад зориулж гар ариутгалын бодис, гар арчих сальфетка зэргийг бэлтгэн байршуулав.



Албан хаагчдыг халдвараас урьдчилан сэргийлэх үүднээс биеийн халууныг өдөрт 2 удаагийн давтамжтай хэмжиж, амны хаалт, ариутгалын материалаар тогтмол ханган ажиллаж байна.



Байгууллагын өрөө, тасалгаа, үйлчилгээний заал, ариун цэврийн өрөө гэх мэт бүх өрөө тасалгаануудыг тогтмол ариутган цэвэрлэж, агаар сэлгэлтийг 2 цаг тутамд хийн ажиллав. Үйлчилгээний заал, өрөө, тасалгаануудад халдвараас урьдчилан сэргийлэх ариутгалыг тогтмол хийж ажилласан.



Хариуцлагатай жижүүрийн хуваарийн дагуу албан хаагч бүр Угтах лавлах үйлчилгээ үзүүлж, иргэдийн биеийн дулааны хэм, холбогдох мэдээллийг тэмдэглэн авав.



Бүртгэлийн үйлчилгээ авахдаа QR кодыг уншуулан халдварын эрсдэлээс өөрийгөө хамгаах боломжтойг иргэдэд зөвлөж ажиллав.



Үйлчилгээний заал болон өрөө, тасалгаа, коридорт халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж бүхий сурталчилгааны зурагт хуудсыг тогтмол шинэчлэн байршуулж, үйлчилгээний танхимийн дэлгэцээр иргэдийг томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөөг мэдээллэн ажиллалаа.



Албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор Чацарганатай Витагрипп ВИТАМИН С, хатаасан аарц, маск, бээлий, гар ариутгагч, салфетка зэрэг зүйлээр хангав.



Ардын уламжлалт бариа заслын эмнэлэгтэй хамтран албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан

#### АРАВ. БУСАД

❖ Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 дугаар зарлиг, Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны А/130 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх, аймгийн Засаг даргын “Чойбалсан хотыг ногоон хөгжлийн чиг баримжаатай хот болгон хөгжүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх” зорилгын хүрээнд эх орон, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, нөхөн сэргээх бүтээлч ажилд оролцов.



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг аймгийн Гэр бүл, Хүүхэд залуучуудын хөгжлийн газраас ирүүлсэн **“ХҮҮХЭД ГЭР БҮЛДЭЭ ЖАРГАЛТАЙ”** уриан дор тэмдэглэн өнгөрүүлэх зөвлөмжийн дагуу байгууллагын албан хаагчдынхаа хүүхдийн хөгжлийг дэмжих, халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, биеийн дархлааг дэмжих зорилгоор эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй витаминь бэлгийн багцыг бэлтгэж хүүхэд бүрт хүргүүлэв.



Байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор аймгийн Тагнуулын газартай хамтран 2020 оны 01 сард цас мөсний баяр зохион байгууллаа.



Албан хаагчдын эв зөийг эрхэмлэх, чөлөөт цагийг цагийг зөв боловсон өнгөрүүлэхээр зуны аялал хийв.



Ахмадын баярын өдрийг тохиолдуулан хэлтсийн 4 ахмад ажилтнуудад баярын мэндчилгээ, үндэсний амин дэмээр баялаг бүтээгдэхүүний багцаар гарын бэлэг хүргүүлэв.



Аймгийн БОЭТ-ийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төвийг тохижуулах “ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗА ГЭЖ ХЭЛЦГЭЭ” уриатай аянд нэгдэж, 200,000 төгрөг хандивлаж оролцов.





Улсын бүртгэгч Ч.Энхцэцэг Коронавируст халдвар / COVID – 19/ -ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх N95 амны хаалт 250 ширхэгийг Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ-ийн хамт олонд хандивласан.



Дорнод аймгийн Хөлөнбуйр суманд 2020 оны 10-р сарын 15-наас 16-ныг шилжих шөнө согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн жолоочийн гэм буруутай үйлдлийн улмаас нэгэн гэр бүлд нөхөж баршгүй уй гашуу тохиолдож, аав, ээж нь амь насаа алдаж, 2 хүүхэд эрүүл мэндээрээ хохирч, өнчрөн үлдсэн. Цаашид 2 хүүхдэд амьдрах урам зориг, амьдралын баталгааг олгох зорилгоор ах, дүү хоёрыг “ХАШАА, БАЙШИН”-тай болгох ЖИГҮҮР ХАЙРЛАЯ” хандивын аянд хамт олноороо нэгдэж, 580.000 төгрөг хандивлалаа.



Шөрмөсний суналт оноштойгоор Солонгос улсад мэс засал хийлгэх Батбилэг хүүд туслах хандивын аянд Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон нэгдэж, 756.000 төгрөгийн бал худалдан борлуулж, сэтгэлийн дэм үзүүллээ.



## АРВАН НЭГ. ДҮГНЭЛТ

Тус хэлтэс нь 2019 онд дэвшүүлсэн “ИРГЭНД ОЙР БҮРТГЭЛИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ”-ний жилийн зорилтыг 2020 онд үргэлжлүүлэн иргэн, хуулийн этгээдийг цахим орчинд мэдээ мэдээллээр ханган ажилласан. Дээрх ажлын үр дүнд хэлтсийн вэб сайт, пэйж хуудасны хандалт, захидлын тоо болон байгууллагын нээлттэй утсанд хандах хандалтын тоо өдрөөс өдөрт өсөн нэмэгдсэн байна. Энэ нь хэлтсээс зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл олон нийтэд ихээхэн хүрсэн байгаа нь харагдаж байна.

Бид цаг үетэйгээ холбогдуулан иргэдэд чиглэсэн “ЭЛЭГ БҮТЭН-ЭРҮҮЛ МОНГОЛ”, “ХАЙРТАЙ ХҮМҮҮСИЙНХЭЭ ТӨЛӨӨ ХАМТДАА СЭРГИЙЛЬЕ”, “ТА АСУУ БИД ЗӨВЛӨЕ” “КОРОНОВИРУС /КОВИД-19/-ИЙН ӨВЧЛӨЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЬЕ” чэйллэнж, нөлөөллийн ажлаараа бусад агентлаг болон хэлтсийн хамт олныг уриалан дуудаж, манлайлан ажиллав.

Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ойг угтан “ТАНД БАЯРЛАЛАА-80 ЖИЛ” аяныг зохион байгуулж, гадагш болон дотогш чиглэсэн 8 шинэлэг, бүтээлч ажлыг зохион байгуулав. Зохион байгуулсан ажлаас товч дурдвал:

- ГЭРЛЭХ ЁСЛОЛЫН БУЛАН
- ХОС БИЧИГТЭЙ ХАЯГЖУУЛАЛТ
- ТҮҮХЭН ЗАМНАЛ- БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЗЭСГЭЛЭН
- АРХИВЫН ЗАСВАР ШИНЭЧЛЭЛ
- НЯГТАРШУУЛСАН ШҮҮГЭЭНИЙ ЖИГДРЭЛТ
- ДҮРЭМТ ХУВЦАСНЫ ШИНЭЧЛЭЛТ
- НЭЭЛТТЭЙ ЦАХИМ ӨДӨР

Бид шинээр гэр бүл болж буй хосуудын гэрлэлтийн баталгааг ёслол төгөлдөр бүртгэн гардуулах зорилгоор орчин цагийн “ГЭРЛЭХ ЁСЛОЛ”-ын буланг байгуулахаар зорьж, аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга нарт санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг хүссэн албан бичиг хүргүүлсэн. Уг санал санаачлагыг дэмжин:

- Аймгийн төвийн нэг цонхны үйлчилгээний төвд 4,673,350 төгрөг
- Баянтүмэн сум 30.000.000 төгрөгийн өртөг бүхий 8 ханатай гэрлэх ёслолын өргөө
- Цагаан-Овоо сум 6.000.000 төгрөгийн өртөг бүхий өргөө
- Бусад сумд нийт 6.000.000 төгрөгийн өртөг бүхий буланг тус тус шинээр байгуулан нийт 46,673,350 төгрөгийн өртөг бүхий ажлыг хийж хэрэгжүүлэв.

Дээрх ажил нь иргэдийн хүлээлтийг мэдэрсэн, шинэлэг ажил болсон нь иргэдээс ирүүлсэн баярласан, талархсан сэтгэгдлээс харагдаж байгаа.

Цаашид бид байгууллагаа сурталчилсан нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэхээс гадна өмнөх жилүүдэд санаачилсан, олны талархлыг хүлээсэн үйлчилгээнүүдээ үргэлжлүүлэн ажиллахыг зорьж байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ДОРНОД АЙМАГ ДАХЬ УЛСЫН  
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ОЮУНБАЯР